Ёс зүйн хорооны 2025 оны ... дүгээр
сарын ...-ний өдрийн ... дугаар тогтоолын
гуравдугаар хавсралт

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН "ТАЙЛАНГИЙН МАЯГТ"[1]

НЭГ. Товч танилцуулга[2]
Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах ажлын хүрээнд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Төрийн албан хаагчийн Ёс зүйн дэд хороонд хандан 2025 онд Төрийн албан хаагч болон иргэнээс нийтдээ 3 гомдол, мэдээлэл ирүүлсэн байна. Гомдол, мэдээллийг Ёс зүйн дэд хорооны хуралдаанаар хэлэлцүүлж, дүгнэлтийг гаргаж, Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын системд баталгаажуулан холбогдох газар, иргэнд хүргүүлэн ажилласан. Ёс зүйн хорооны 2024 оны 13 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-д заасны дагуу яамны цахим хуудсанд нийтэлсэн. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 15 дугаар зүйлд 15.1-д заасны дагуу гомдол, мэдээллийг хүлээн авах зорилгоор цахим шуудан /ethic_khoroo@mudch.gov.mn/ үүсгэж, байгууллагын албан хаагчдад мэдээлэл хүргэж, гомдол, мэдээллийг хянан шалгах үйл ажиллагааны явцад мэдээллийг хуваарилах, дамжуулах, хянан хэлэлцэхдээ ашиглаж байна.
ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3]:
Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6.3, Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн 2.1.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд Удирдлагын академи болон Ес зүйн хороо хамтран зохион байгуулсан "Ёс зүйн сургагч багш" бэлтгэх сургалтад тус яамны Ёс зүйн дэд хорооны гишүүн бөгөөд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Х.Ган-очир, Төрийн албаны зөвлөлийн Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх салбар зөвлөлийн гишүүн СХОГ-ын Төсөл, хөтөлбөрийн хэлтсийн шинжээч Д.Баярмаа нар амжилттай суралцан төгссөн. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн хэм хэмжээг сахиулах ажлын хүрээнд ёс зүйн сургагч багш нар 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдөр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Төрийн албан хаагчийн Ёс зүйн дэд хорооны гишүүд болон харьяа байгууллагын дэд хороодын гишүүдэд зориулан "Төрийн албан хаагчийн үнэт зүйл, төрийн албан хаагчийн ёс зүйн ойлголт, зарчим", "Ёс зүйн зөрчлийг тогтоох, бүртгэх болон ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх, дүгнэх", "Ёс зүйн зөвлөн туслах үйл ажиллагаа, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах, Ёс зүйн эрсдлийн үнэлгээний ойлголт"-ын чиглэлээр сургалт явуулж, дасгал кэйс ажлуулсан. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн хэм хэмжээг сахиулах ажлын хүрээнд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Төрийн албан хаагчийн ёс зүйн дэд хорооноос 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдөр Төрийн албан хаагчийн ёс зүй, ёс зүйн хороо болон дэд хорооны үйл ажиллагаа, баримталж буй бодлого, чиглэл, арга хэмжээний талаар танилцуулах сургалт, мэдээллийг яамны албан хаагчдыг оролцуулан

[1] Маягтын дагуу тайланг 5 хуудаснаас ихгүй, товч үр дүнг нэгтгэн ирүүлнэ.

[2] Байгууллагын харьяа салбар, нэгжийн хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх байдлын талаар товч мэдээллийг тайлагнана.

[3] Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны талаар тайлагнана.

зохион байгуулсан. Ёс зүйн хорооноос 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдөр ёс зүйн хорооны гишүүдэд зохион байгуулсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам” болон Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд системийг ашиглах, системд бүртгэсэн мэдээллийг хянах заавар, зөвлөгөө өгөх, арга зүйгээр хангах сургалтад Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Төрийн албан хаагчийн Ёс зүйн дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүд хамрагдсан. Ёс зүйн хорооноос 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулсан Төрийн албан дахь ёс зүйн асуудал ба зөрчил, Иргэд болон төрийн албан хаагчдын санаа бодлыг тандах тоон болон чанарын судалгаа, Ёс зүйн зөрчлийн шалтгаан, нөхцөл, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тогтоох, бууруулах чиглэлээр урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахад ашиглах арга зүй, аргачлал, зөвлөмжийн явцын үр дүн болон “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээ”-ний үр дүнг танилцуулах хэлэлцүүлэг Ёс зүйн дэд хорооны гишүүд оролцсон. Төрийн албаны зөвлөлөөс 11, 12 дугаар сард зохион байгуулсан Төрийн албаны бодлого боловсруулах, шийдвэр гаргах, хяналт тавих, хууль эрх зүйн чиг үүрэг бүхий албан тушаалтан нарт хүний эрх, ёс зүй, жендэрийн эрх тэгш байдлын талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлж, хариуцлагатай, шударга, иргэндээ үйлчилдэг төрийн байгууллагын соёлыг төлөвшүүлэх богино хугацааны зорилтот сургалт, хэлэлцүүлгүүдэд тус яамны Төрийн нарийн бичгийн дарга М.Баяраа, Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Б.Найрамдал, Хуулийн хэлтсийн дарга Б.Сүхбат, ТЗУГ-ын Яамны хүний нөөц, шагнал хариуцсан ахлах шинжээч Т.Янжмаа нар оролцсон.

2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд Ёс зүйн хууль тогтоомжийг хэрэгжүүлж, Ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхжуулах сургалтад хамруулж, Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, гишүүдийг урамшуулан ажиллаж байна.

2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон Ёс зүйн хорооны баталсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-д заасны дагуу Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Төрийн албан хаагчийн Ёс зүйн дэд хороог Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/70 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна. Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын системд 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр нэвтрэх эрхийг үүсгүүлж, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Төрийн албан хаагчийн Ёс зүйн дэд хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн мэдээлэл болон дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг системд оруулсан. Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг дэд хорооны 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны дэргэдэх Төрийн албан хаагчийн Ёс зүйн дэд хорооны 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан, ёс зүйн дэд хорооны гишүүдийн мэдээллийг 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 08/2455 дугаар албан бичгээр Ёс зүйн хороонд хүргүүлсэн.

Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
Албан хаагчид байгууллагын соёлын үнэ цэнийг дээдэлж, хувь хүний зан суртахуун гэхээс илүүтэй баг хамт олны итгэл үнэмшил,үнэ цэнийг эрхэмлэх нь нэмэгдсэн.	Санхүү төсвийн хязгаарлагдмал байдал нь ёс зүйн сургалт, сурталчилгаа, эрдэмтэн судлаачдыг урьж лекц, илтгэл тавиулах, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа зохион байгуулахад хүндрэлтэй байна.

Санал:

Төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой УИХ-ын 1 тогтоол, УИХ-ын байнгын хорооны 3 тогтоол, Засгийн газрын 2 албан даалгавар гарсан байна. Эдгээр тогтоол шийдвэр нь агуулгын хувьд давхардалтай ижил тул хэрэгжүүлж ажиллахад хүндрэл гарч байна. Олон давхардсан шийдвэрүүдийг хүчингүй болгож, нэгдсэн нэг шийдвэр гаргах.

Шалгах хэсэг:

- ☑ “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- ☑ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.
- ☑ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан
Төрийн нарийн бичгийн даргын
албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч М.Баяраа
/Албан тушаал/ */Гарын үсэг/* */Гарын үсгийн тайлал/*

Ёс зүйн дэд хорооны дарга
Барилга, барилгын материалын
бодлого, зохицуулалтын газрын
ахлах шинжээч Д.Болормаа
/Албан тушаал/ */Гарын үсэг/* */Гарын үсгийн тайлал/*

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга
Хот байгуулалт, орон сууцжуулалтын
бодлого, зохицуулалтын газрын
ахлах шинжээч Б.Мөнхбаяр
/Албан тушаал/ */Гарын үсэг/* */Гарын үсгийн тайлал/*

Огноо: 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр

Ёс зүйн хорооны 2025 оны ... дугаар
сарын ...-ний өдрийн ... дугаар тогтоолын
нэгдүгээр хавсралт

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ
“ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ”

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо[1]	Хувийн жин[2]
1	2	3		4	5	6
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3] (ҮХХ)	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн баталсан эсэх[4]		1	1	10
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх [5]		1	1	10
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх [6]	0,5	0,5	5
			Соён, гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал[7]	0,5	0,5	5
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал[8]	0,5	0,0	0
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал[9]	0,5	0,5	5
Хэсгийн оноо				**4**	**3.5**	**35**
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ)	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх [10] (*гарсан дүгнэлтийн хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо)*		1	1	10
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал[11]		1	1	10
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал[12]		1	1	10
Хэсгийн оноо				**3**	**3**	**30**
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал[13]		1	1	10
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал [14] *(Гомдол ирээгүй бол 1 оноо авна, нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын хувийн жингээр тооцно)*		1	1	10
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал [15]		1	1	10
Хэсгийн оноо				**3**	**3**	**30**
Үнэлгээний нийт оноо, хувь				**10**	**9.5**	**95**

$$\text{Эзлэх хувь} = \frac{\text{ҮХХ} + \text{ЁЗМ} + \text{ЁЗДХ}}{10} * 100\%$$

Тайлбар:

[1] Байгууллагын өөрийн болон харьяа, салбар байгууллагад өгсөн үнэлгээ.
[2] Авсан оноог 10-аар үржиж хувийн жинг тооцох ба нийт дүн 100-с хэтрэхгүй байна.
[3] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”.

[4] ЁЗХ-ны 2025 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт”-д нийцүүлэн батлагдсан төлөвлөгөөг хавсарган ирүүлнэ.

[5] ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар "Аргачлал батлах тухай" тогтоол.

[6] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн 2.1 дэх хэсэг, ЁЗХ-ны 2024 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын 4.1.3, мөн оны 15 дугаар “Сургалтын агуулга, сэдэв батлах тухай” тогтоол.

[7] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалт.
[8] ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал"-ын 8.3.3, мөн оны 07 дугаар "Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргах, шалган шийдвэрлэх талаар авах арга хэмжээний тухай" тогтоол.

[9]ЁЗХ-ны 2024 оны 13 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам”-ын 3.8 дахь хэсэг, 2025 оны 08 дугаар "Загвар батлах тухай" тогтоол.

[10] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалт.
[11] Мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг.
[12] Мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт.
[13] ЁЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам”-ын 4.2.2 дахь заалт.

[14] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.1 дэх заалт.
[15] ЁЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам”-ын 4.4.3, 4.4.4 дэх заалт.

-oOo-

БАТЛАВ: ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА

Д.БОЛОРМАА

ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Уриа: "Ёс зүйтэй төрийн албан хаагч, манлайлалтай Ёс зүйн дэд хороо" 2025.01.20

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Тоо чанар, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцах албан тушаалтан
Нэг: Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:				
1.1.	Ёс зүйн дэд хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөг тухай бүр батлуулан, хуралдааны бэлтгэлийг хангах, хуралдааны шийдвэр, тэмдэглэлийг зохих журмын дагуу албажуулах, холбогдох байгууллага, томилох эрх бүхий албан тушаалтан, зөрчилд холбогдсон албан хаагч, гомдол, мэдээлэл гаргасан албан хаагчид хүргүүлэх ажлыг зохион байгуулах	Жилдээ	Хуралдааны бэлтгэл ажил бүрэн хэрэгжсэн байна. - Хуралдаан: Тухай бүр - Хуралдааны тэмдэглэл: Тухай бүрд	Дэд хорооны гишүүд, Дэд хорооны нарийн бичгийн дарга
1.2.	Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын системд Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн, төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт, гомдол, мэдээллийг бүртгэх	Тухай бүр	Бүртгэгдсэн гомдол, мэдээллийн тоо Шийдвэрлэлтийн хувь	Дэд хорооны нарийн бичгийн дарга
1.3.	Ёс зүйн хорооны ажлын албанд Ёс зүйн дэд хорооны ажлын тайлан, мэдээг тогтоосон хугацаанд дээд шатны байгууллагад хүргүүлэх	Журмын хугацаанд	Эхний хагас жилийн тайланг 2025.06.30-ны өдрийн дотор, жилийн тайланг 2026.01.30-ны өдрийн дотор хүргүүлсэн байна.	Дэд хорооны нарийн бичгийн дарга

			Бусад мэдээ, тайланг хугацаанд нь гарган хүргүүлсэн байна. Хүргүүлсэн тайлан, мэдээний тоо: 2	
1.4.	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг боловсруулах, хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг хагас, бүтэн жилээр тайлагнах	Хагас, бүтэн жил	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны төлөвлөгөө хэрэгжиж, төрийн албан хаагчидтай холбоотой аливаа асуудал тухай бүр шийдвэрлэгдсэн байна. Төлөвлөгөө-1, Тайлан-2.	Дэд хорооны гишүүд, Дэд хорооны нарийн бичгийн дарга
1.5.	Төрийн болон албаны нууцын тухай, Төрийн албаны тухай болон бусад хууль тогтоомжийн дагуу Ёс зүйн дэд хорооны архив, албан хэрэг хөтлөлтийг бүрдүүлж хангах	Жилдээ	Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, архив, албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын дагуу зохион байгуулсан байна. Хадгаламжийн нэгжийн тоо:	Дэд хорооны нарийн бичгийн дарга
Хоёр: Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах хүрээнд:				
2.1.	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн хэм хэмжээг сахиулах ажлын хүрээнд сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж арга зүйгээр хангах	Жилдээ	Сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулсан байна. Сургалт-4 Сурталчилгаа-2	Дэд хорооны гишүүд, Дэд хорооны нарийн бичгийн дарга
2.2.	Ёс зүйн хороо болон бусад байгууллагаас зохион байгуулах “Ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхжуулах” сургалтад хамрагдах	Жилдээ	Хамрагдсан сургалтын тоо	Дэд хорооны гишүүд, Дэд хорооны нарийн бичгийн дарга
2.3.	Байгууллага ёс зүйн төлөвшил, шударга байдлын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, төрийн албан хаагчийн харилцаа, хандлагыг төлөвшүүлэх чиглэлээр хувийн хэвшил, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.	Жилдээ	Хувийн хэвшил, иргэний нийгэм, хэвлэл мэдээлэл, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажилласан байна. Арга хэмжээ-тухай бүр, тоо	Дэд хорооны гишүүд, Дэд хорооны нарийн бичгийн дарга
2.4.	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хянан	Жилдээ	Дүгнэлтийн тоо: Тухай бүр, тоо	Дэд хорооны гишүүд,

	шалгаж, дүгнэлт гаргаж, эрх бүхий байгууллага, албан тушаалтан, гомдол, мэдээлэл гаргасан этгээд, зөрчилд холбогдсон албан хаагчид хүргүүлэх			Дэд хорооны нарийн бичгийн дарга
2.5.	Салбар, байгууллага, нэгж дотроо гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчил, түүний шалтгаан, эрсдэлийг тодорхойлох, дүн шинжилгээ хийх, байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан нэгж, эсхүл албан хаагчид зөвлөмж хүргүүлэх;	Жилдээ	Хувийн хэвшил, иргэний нийгэм, хэвлэл мэдээлэл, судалгааны байгууллага, мэргэшсэн баг, судлаачийн оролцоог хангаж, хамтран ажилласан байна. Эрсдлийн үнэлгээ -1 Зөвлөмж - 1	Дэд хорооны гишүүд, Дэд хорооны нарийн бичгийн дарга
Гурав: Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:				
3.1.	Яамны албан хаагчдын ёс зүйн зөрчилд судалгаа хийж нэгтгэн, үнэлгээ хийх	Жилдээ	Ёс зүйн хорооноос баталсан аргачлалын дагуу үнэлгээг хийсэн байна	Дэд хорооны гишүүд, Дэд хорооны нарийн бичгийн дарга
3.2.	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны мэдээ, тайланг олон нийтэд ил тод нээлттэй мэдээлж, байгууллагын соёлыг төлөвшүүлэх чиглэлээр нээлттэй санал хүсэлтийн цахим хуудсыг нэвтрүүлэх.	Жилдээ	Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж буй цахим хуудсанд албан хаагчид санал хүсэлтээ илэрхийлэх дэд цэс үүссэн байна.	Дэд хорооны гишүүд, Дэд хорооны нарийн бичгийн дарга

Танилцсан:

Ёс зүйн дэд хорооны гишүүн /Х.Ган-Очир/

Ёс зүйн дэд хорооны гишүүн /Д.Гэрэлмаа/

Ёс зүйн дэд хорооны гишүүн /Д.Бэлэгсайхан/

Ёс зүйн дэд хорооны гишүүн /Ц.Уганбаяр/

Ёс зүйн дэд хорооны гишүүн /Г.Гантөр/

Боловсруулсан:

Ёс зүйн дэд хорооны Нарийн бичгийн дарга Б.Мөнхбаяр /Б.Мөнхбаяр/